



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 05 сарын 25 өдөр

Дугаар A/40


Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдаж авах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах заалт болон Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндсэн хөрөнгө худалдан авах зүйлсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Байгууллагын албан хэрэгцээнд “Үндсэн хөрөнгө худалдан авах” ажил зохион байгуулахыг Ерөнхий инженер бөгөөд барилга байгууламжийн инженер Г.Пүрэвдоржд үүрэг болгосугай.
3. “Үндсэн хөрөнгө худалдан авах” ажил зохион байгуулахад шаардлагатай үнэ болох 1,860,800 /Нэг сая найман зуун жаран мянган найман зуун/ төгрөгийг холбогдох зардлаас санхүүжүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг нягтлан бодогч Г.Батням-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэнд хянал тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга Г.Цэнджав-т даалгасугай.

ДАРГА




М.ГОНЧИГЖАВ

3150600040

“Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл,
технологийн парк” орон нутгийн өмчит
төсөвт үйлдвэрийн газрын даргын 2016 оны

05 сарын 05 өдрийн 4/10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ҮНДСЭН ХӨРӨНГӨ ХУДАЛДАН АВАХ ЖАГСААЛТ

	Тавилга	Хэмжээ	Тоо /ширхэг /	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Архивын төмөр шүүгээ	85 см*185 см	2	240,000	480,000
2	Ажлын ширээ	140 см	1	450,000	450,000
3	Уулзалтын ширээ	160 см	1	200,000	200,000
4	Уулзалтын ширээний сандаг	30см *30 см	4	40,000	160,000
5	Ажлын ширээ / жижиг /	140см *140см	1	250,800	250,800
6	Уулзалтын ширээ	200 см	1	320,000	320,000
	Нийт				1,860,800

--oOo--